

ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
1.1. Үйлдвэрийн товч танилцуулга.....	3
1.2. Үйлдвэрд ашиглаж буй тоног төхөөрөмж	4
1.3. Үйлдвэрийн технологи	5
1.4. Үйлдвэрийн БО-ны төлөв байдал.....	7
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
2.1. Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний тухай.....	10
2.2. Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт	10
2.3. Хөрсний бохирдол, эвдрэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт	12
2.4. Усан орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт.	14
2.5. Ургамлан бүрхэвчийн бохирдол бууруулах чиглэлээр авч авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт.	15
2.6. Оршин суугчид, ажиллагсадын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалын сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт.....	16
2.7. Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
ДӨРӨВ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
ТАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	27
7.1. Агаар орчин	27
7.2. Хөрсний бохирдол, элэгдэл	33
7.3. Усан орчны бохирдол.	36
7.4. Ургамлан бүрхэвчийн бохирдол.....	37
7.5. Цементийн үйлдвэрийн орчин дахь амьтан.....	38
7.6. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнасан хувиарь	38
НАЙМ. ТӨСӨВ	39
ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД	40

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Энэхүү хөтөлбөрийг “Теем смайл” ХХК-ийн 2023 онд гүйцэтгэсэн БОНБНУ-ний тайлангийн нэмэлт тодотгол болон Байгаль Орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”- ыг үндэслэн боловсруулав.

1.1. Үйлдвэрийн товч танилцуулга

Үйлдвэрийн нэр: "Цемент, шохойн үйлдвэр"

Үйлдвэрийн зорилго: Монгол Улсын MNS974:2008 стандартын шаардлага хангасан OPC42.5ба PPC32.5 ангийн портланд цементийг 2008 оноос, MNS347-2002 стандартын шаардлага хангасан шохойг 2024 оноос үйлдвэрлэж, барилгын салбарт өсөн нэмэгдэж буй цемент, шохойны хэрэгцээний тодорхой хэсгийг хангах зорилготой.

Үйлдвэр: "Налгар түшиг" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9019015028
Регистрийн дугаар: 5045924

Үйлдвэрийн байршил: Улаанбаатар хотын Налайх дүүргийн 4-р хороо, Зэвсэгт хүчний 337-р ангийн нефтийн агуулахын баруун талд 13.5 га талбайг хамарна.

Газарзүйн солбицол:

№	Өргөрөг	Уртгаг	Д.Т.Д
1	47°46'37.5"	107°18'42.4"	1419 м
2	47°46'30.3"	107°18'51.6"	1409 м
3	47°46'22.2"	107°18'37.7"	1411 м
4	47°46'27.9"	107°18'29.7"	1419 м

Дэд бүтэц: Налайх дүүрэг нь УБ хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон. Тус үйлдвэр нь дэд бүтэц сайн хөгжсөн Налайх дүүргийн 110/35/10 кВт-ын “Налайх дэд станцаас” агаарын 3 км шугам татаж, 1000 кВа, 800 кВа-ын 2 трансформатер бүхий ХТП суурилуулж цахилгааны эх үүсвэрээр хангадаг. Хөдөлгөөнт болон суурин утас, интернет гэх мэт харилцаа холбоо сайн хөгжсөн.

Хүчин чадал: Цементийн үйлдвэр нь жилд 100.0 мян.тн OPC42.5 ба PPC32.5 ангийн портланд цемент ба 50,000 тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Цементийн үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж нь түүхий эд материалын бутлах хацарт бутлуур, циклон дулаан солилцуулагч бүхий эргэх зуух, түүхий хольц эсвэл шохой, цементийн тээрэм зэрэг болно.

Ажиллах хүч: Үйлдвэрт байнгын 70 гаруу хүн ажилладаг.

Ажиллах хугацаа: 2008 оноос эхлэн тогтвортой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн ба цаашид тогтмол ажиллана.


Үр ашиг: Тухайн үйлдвэр нь харьяалагдах засаг захиргааны нэгжийн нийгэм, эдийн засагт орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, холбогдох татваруудыг төлөх, ажилчдыг үнэ төлбөргүй орон сууцаар хангах зэргээр үр ашигтай ажиллаж байна.

Эцсийн бүтээгдэхүүн: Монгол Улсын MNS974:2008 стандартад нийцсэн цемент, MNS347-2002 стандартанд нийцсэн шохой байна.



Зураг-1. “Налайх” цемент, шохойн үйлдвэрийн ерөнхий байдал

Цементийн үйлдвэрийн засаг захиргааны харьяалал



Зураг-2. Үйлдвэрийн байршил

1.2. Үйлдвэрт ашиглаж буй тоног төхөөрөмж:

Цемент, шохойн үйлдвэр нь жилд 100.0 мян.тн OPC42.5 ба PPC32.5 ангийн портландцемент үйлдвэрлэх эсвэл тухайн тоног төхөөрөмжөөр жилд 50,000 тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Цемент, шохойн үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжид дараахи тоног төхөөрөмжүүд ордог болно. Үүнд:

Хүснэгт-1. Цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд

Д/Д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоног төхөөрөмжийн марк	Тоног төхөөрөмжийн хүчин чадал
1	Хацарт бутлуур	PE400x600	17-40 тн/цаг
2	Булт бутлуур	YGP: 700	18-20 тн/цаг
3	Түүхий эдийн тээрэм	Ø=2.2*6.5 м	11-15 тн/цаг
4	Туузан дамжуулагч	L500x40	45 тн/цаг
5	Тоос шүүх филтэр	Ø =2*14 м	200м ³
6	Цахилгаан филтэр	W-113	200м ³
7	Скруббер	No15.5	700 м ³ /цаг
8	Тоос шүүх цахилгаан филтэр	W-113	200м ³
9	Эргэх зуух	W-2835	7.0 тн/цаг
10	Хөргөгч	L 2225	9.0 тн/цаг
11	Нүүрсний тээрэм	1835	5-10 тн/цаг
12	Цементийн тээрэм	Ø=2.2*9 м	10-15 тн/цаг
13	Савлах машин	BGLW	30 тн/цаг

1.3. Үйлдвэрийн технологи:

Цементийн клинкер үйлдвэрлэх үндсэн 4 арга байдаг байна. Үүнд:


- 1. Нойтон арга:** Өндөр нам титртэй зутанг тодорхой найрлагатай бөгөөд 36-45% устай холиж хутгана. Нойтон аргын үед урт зуух хэрэглэнэ. 150-200 м-ийн урттай, 4-7 м орчим диаметртэй, хүчин чадал нь 1000-3000 тн чулуунцар хоногт үйлдвэрлэх хүчин чадалтай. Зуухыг 3-4⁰ налуу байрлуулдаг, түлшээр нүүрс, газ, мазут хэрэглэнэ. Зууханд нэг талаас зутан нөгөө талаас халуун хий ирнэ. Зутан зууханд дээрээс доошлох тусам хөдлөх явцад зутан халж, хатаж, задарч, хамгийн халуун хэсэгт 1450⁰C хүрч чулуунцар үүсэх процесс төгсөнө. Зуухнаас гарсан чулуунцар хөргөгчөөр дамжин гарч агуулахад сайтар хөрнө. Чулуунцарыг, гөлтгөнө, нэмэлтийн тээрэмдэн гаргаж авна.
- 2. Хагас хуурай арга:** Түүхий эдийн хольцыг хуурай аргын адил бэлдэнэ. Түүхий эдийн нунтаг хольцыг барабан болон тавган үрэлжүүлэгчид үрэлжүүлнэ. Үрлийн хэмжээ 10-20 мм, чийглэг 11-16% байна. Үрэлжсэн түүхий эдийн хольцыг конвейрийн кальцинаторт орно. Кальцинатор нь хөдөлгөөнгүй төмөр арьсанд байрлах хөдөлгөөнт төмөр колосникуудаас бүрдэнэ. Колосникуудын хурд 25-50 м/ц. Зуухнаас гарч байгаа халуун хий колосник дээр байгаа үрүүлдийг халааж, хатааж 20-30 хувийг декарбоназацид оруулна. Түүхий хольц энд 900⁰C хүртэл хална. Ингэж бэлтгэгдсэн үрлүүд эргэх зууханд орж чулуунцар үүсэлтийн процесс бүрэн явагдаж дуусана. Бусад процессууд нойтон, хуурай аргатай адил байна.
- 3. Хосолмол арга:** Нойтон аргаар зутан бэлтгэж вакуум филтэрт оруулан 16-20% чийгтэй брекитийг зуухны буцах тоостой холин хагас хуурай аргын зууханд шатааж чулуунцар гарган авна. Бусад процесс адил.
- 4. Хуурай арга:** Шохойн чулуу шаварыг урьдчилан бутлаж 1% чийгтэй болтоол хатаана. Шохойн чулуу шавар хоёрыг тусад нь хатаана. 1970-1980-аад оны үеэс түүхий хольцийг нунтаглан хатаах процессийг хамтад нь хийдэг сеператор тээрмүүд гарсан юм. Энэ аргыг одоо өргөн хэрэглэж байна. Түүхий эдийг тодорхой жигд химийн найрлагатай болгохын тулд хутгаж, дараа нь тохируулах силосд хийнэ. Нэг силост өндөр нам титртэй бэлтгээд

дээрээс нь тохируулах хольцийг нэмнэ. Тохируулсан түүхий эдийн хольцийг циклон дулаан солилцуулагчид шахна. Циклон дулаан солилцуулагч нь голдуу 4 шаттай байдаг. Хоорондоо болон зуухтай труба, хоолойгоор холбогдсон байна. Хуурай аргын зуух нь 40-70 м урттай байна. Бүх циклонуудыг дамжиж гарахдаа түүхий хольц 700-800⁰С хүртэл халдаг ба чийгээ бүрэн алдаж 20-25% нь декарбонизид ордог. Циклоноос материал эргэх зууханд орж чулуунцар үүсэх процесс явагдаж дуусна. Зуухнаас чулуунцар хөргөгчид орж хөрнө. Дараа нь чулуунцарын складанд нөөцлөгдөнө. Бусад технологийн горим нь нойтон аргын зуухтай адил байна.

"Налгар түшиг" ХХК нь цемент үйлдвэрлэх дээрх аргуудаас хамгийн сүүлийн үеийн технологи болох хуурай аргыг нь сонгосон. Хуурай арга нь нойтон аргатай харьцуулахад эдийн засгийн хувьд ашигтай бөгөөд байгаль орчинд бага нөлөөтэй байдаг. Хуурай аргын дутагдалтай тал нь нунтаглах үеийн тоосжилт ихтэй байдаг. Цементийн үйлдвэр нь доорх үе шаттайгаар явагдана. Үүнд:

- ✓ Уурхайгаас түүхий эдийг олборлох, тээвэрлэх
- ✓ Түүхий эдийг бутлах, хатаах
- ✓ Тохиромжтой найрлагатай түүхий хольцыг бэлтгэн тээрэмд нунтаглах
- ✓ Эргэдэг зууханд түлшээр боловсруулалт хийж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу клинкер үйлдвэрлэх
- ✓ Клинкерийг хөргөх
- ✓ Клинкерийг гөлтгөнө болон бусад нэмэлтүүдтэй хольж тээрэмдэн нунтаглаж бэлэн бүтээгдэхүүн буюу цемент гарган авах
- ✓ Цементийг хадгалах, савлах

Цементийн үйлдвэрийн технологийн схемийг дараах зурагт харууллаа. “Налгар түшиг” ХХК нь цементийн үйлдвэрийг зөвхөн дулааны улиралд ажиллуулахаар төлөвлөсөн байна.



Зураг-3. Үйлдвэрийн технологийн схем

1.4. Үйлдвэрийн байгаль орчны төлөв байдал

Газарзүйн бүсчлэл:

Газарзүйн байршлын хувьд Зүүн Монголын төв хэсэг, Хангай-Хэнтийн уулархаг муж, Бага Хэнтийн нурууны өмнөд салбар уулсын хотгорт оршино.

Цаг уур, уур амьсгал:

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, тэсгэм хүйтэн өвөл, халуун зун, агаарын хэмийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай. Баруун, баруун хойд зүгээс зонхилох салхитай. Жилийн дундаж агаарын хэм -8°C , нийлбэр хур тунадас 238 мм байна.

Усан сүлжээ:

Налайхын хотгорын нийт талбайн хэмжээнд голын сүлжээний нягтшил багатай. Уурхайн талбайн хойгуур 8-10 км зайд Туул гол урсан өнгөрдөг. Гидрогеологийн хувьд уст түвшин 11,2-27,5 м, худгийн ундарга 0,5-10,8 л/с хүрдэг.

Хөрс:

Хөрсний M1:100000 масштабтай байрзүйн зураг болон хээрийн судалгааг үндэслэн Налайх дүүрэг орчим уулын ойн ширхэгт бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн, нимгэн хар хүрэн, нугын цэвдэгт, нугын хужир мараалаг, аллювыннугын давсархаг хөрс тархсан болохыг тогтоосон. Үйлдвэр, уурхай нь хээрийн хар хүрэн хөрсний дэд бүсэд орших тул сайр чулуурхаг байдал, ялзмагт үеийн зузаанаараа ялгаатай хар хүрэн хөрсний төрлүүд тархсан.

Ургамлан бүрхэвч:

Судлаачдын дүгнэлтээс харвал ургамлан нөмрөг ихээхэн талхлагдсан, одоогоор хөл газрын ургамал болох алаг өвс-шарилж, улалж гэх мэт нь алаг цоог ургасан.

Амьтны аймаг:

Сахалт багваахай, дагуур огодой, урс сүүлт зурам, орог зусаг, үлийн цагаан оготно, хярс, өмхий хүрэн зэрэг нь нутаглана. Техноген системийг даган амьдардаг шувуудаас тагтаа, сохор элээ, шаазгай, хэрээ, улаан хошуут, бор шувуу зэрэг нь элбэг тохиолдоно.

Геологийн тогтоц:

Налайхын хотгорын хүрээлэн буй уулсууд нь девон, карбоны настай хурдас чулуулгаас, хотгор нь цэрдийн тунамал чулуулгаас тогтож, түүний дээр неогений болон дөрөвдөгчийн сэвсгэр хурдас тархсан.

Үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус үйлдвэрийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, хөрс, газрын гадарга, ургамал, амьтан юм.

Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, үйлдвэрийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг хийсэн болно.

Гол сөрөг нөлөөлөл:

үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллүүдээс агаар орчны бохирдол, хүний эрүүл мэнд нь гол сөрөг нөлөөлөлд өртөгч объект болох нь судалгаагаар тогтоогдож байна. Голлох нөлөөллийг тодруулахад дараах зүйлүүдийг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

- ✓ Үйл ажиллагааны (бохирдлын) түвшинг тодорхойлох
- ✓ үйлдвэрийн альтернатив хувилбаруудыг зааж өгөх
- ✓ Нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг тодорхойлох

үйлдвэрийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагавар нь харилцан адилгүй байна.

Үйлдвэрийн шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл:

Цементийн үйлдвэрийн үйл ажиллагааны үед үйлдвэрийн байршил, үйлдвэрийн техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлан жагсаах аргыг хэрэглэн түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт-2: Үйлдвэрийн шийдэл, төлөвлөлтийн болзошгүй нөлөөлөл

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Гол үрдагавар		
		Бага	Дунд	Их
1. Үйлдвэрийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын голдрилыг эвдэж, өөрчлөх	х			
Хүн амыг нүүлгэн шилжүүлэх	х			
Үерийн аюулд өртөх	х			
Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворыг эвдэх	х			
Усан хангамжийн асуудлаар өөр байгууллагатай зөрчилдөх	х			
Булаг шандын усны горимд өөрчлөлт орох	х			
2. Үйлдвэрийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх		х		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд сонгосон технологи орчны бохирдолтод хэр нөлөөлөх		х		
Үйлдвэрлэлийн процесс нь ажилчдын эрүүл мэндэд хэр нөлөөлөх, түүнийг саармагжуулах арга хэмжээг авсан эсэх		х		
Цемент үйлдвэрлэх үед болон тоос, хорт бодисоос хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан			х	
Агаарын чанарыг хамгаалах, хянах асуудал			х	
Газрын доорхи усны чанарыг хамгаалах, хянах асуудал		х		
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий хэрэглэдэг эсэх		х		
Дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих үеийн байгаль орчны асуудал				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	х			
Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл			х	
Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл		х		
4. Үйлдвэр ажиллах үеийн байгаль орчны асуудал				
Үйлдвэрийн үйл ажиллагааны болон ашиглалтын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				х
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)				х
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх		х		
Хөрш зэргэлдээх газрын ашиглалтад хохирол учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх	х			
Цементээс гадна өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг авч үзсэн эсэх	х			
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				х
5. Үйлдвэрийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	х			
Үйлдвэрийн техник технологийн шийдлийг техник, эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх			х	

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний тухай

Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөө нь байгаль орчин хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг “Налгар түшиг”ХХК нь байгаль орчинд ээлтэй эерэг талаас нь боловсруулсан ба шаардлагатай хөрөнгө мөнгө, зардлыг тухайн жилийн төсөвт тусган төлөвлөгөөг саадгүй хэрэгжүүлэн ажилласан.

Хууль зүйн үндэс:

Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Барилгын тухай”, “Ариун цэврийн тухай”, “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулиуд болон Засгийн Газар, Байгаль орчны болон бусад холбогдох яамнаас гаргасан заавар журмыг мөрдлөгө болгон боловсруулсан.

Энэхүү төлөвлөгөөнд цементийн үйлдвэрийн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээг тусгасан болно.

Байгаль орчин, техник технологийн асуудал:

Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хаягдлыг хадгалах, зайлуулах, орчны бохирдлыг багасгах, гал түймэр гарах эрсдлийг бууруулах, цемент үйлдвэрлэх үйл явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бусад аюул осол, эрсдэлээс сэргийлэх арга технологийг нарийвчилсан үнэлгээний тайлангийн тусгасан бөгөөд түүний хүрээнд уг тайланг боловсруулсан.

Байгаль орчин-нийгэм эдийн засгийн асуудал:

Нийт 60 гаруй хүн ажлын байраар хангаж, тэдгээрийн нийгмийн асуудлыг цогцоор шийдэхийн зэрэгцээгээр дүүргийн төсөвт 1.5-1.6 тэрбум төгрөгийн татварыг жил бүр оруулж байна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрийн байршлын газрыг нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалахтай холбоотой бүх зардлыг “Налгар Түшиг” ХХК өөрийнхөө үйл ажиллагааны зардалд оруулан гүйцэтгэсэн болно.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт:

Байгаль орчныг хамгаалах зохион байгуулалт, төлөвлөлт болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг “Налгар Түшиг” ХХК бүрэн хариуцан ажилласан. БОМТ, ОХШХ-ийг тайлант хугацаанаас өмнө урьд жилийн тайлангаа хүргүүлсэн. БОМТ-нд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх тусгай хөтөлбөр гарган ажиллахын зэрэгцээ төлөвлөгөөний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, хэлэлцэн шийдвэрлэдэг болно.

2.2. Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1) Нөлөөллийн үүсэх шалтгаан:

Цементийн үйлдвэрийн технологийн процессуудын үед (бутлах, тээрэмдэх, шатаах, савлах г.м) агаарт тоос, утаа угаар хаягдаж агаарт бохирдол үүсгэнэ.

2) Нөлөөлөлд өртөх объект:

Үйлдвэрийн орчны агаар, түүгээр дамжин ойр орчмын хүн, амьтан, ургамал, хөрс




Зураг-4. Тоосны хэмжилт хийсэн цэгүүдийн байршил

3) Холбогдох стандарт норм:

- MNS ISO 4227:2002. Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө
- MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5885:2008. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 6063:2010. Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
- MNS4990:2000. ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

Хүснэгт-3. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Гадна болон дотор агаарын тоосжилт болон агаарын тоосны агууламж (PM10, PM2.5), SO ₂ , NO ₂ , дуу чимээг 8 цэгт хөндлөнгийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн.	2024	350,0	Мэргэжлийн байгууллага
2	Тоос шүүх системүүдийн үйл ажиллагаанд их засвар хийж, хуримтлагдсан тоосыг байнгын эргүүлэн ашигладаг болгосон.	2024	1,750,0	Үйлдвэр
3	Тоосжилт ихтэй үйлдвэрийн төв цэгт усан оргилуур болон хаягдал усыг ашиглан автомат тоос дарагч төхөөрөмж сууриулсан ба хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
4	Тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажилласан	2024	Дотоод зардал	Үйлдвэр
Дүн			2,000,0	



Зураг-5. Үйлдвэрийн усан оргилуурын байдал

4) Ажиглалт хяналт явуулсан байдал:

- Мэргэжлийн байгууллагуудаар 1 удаа агаарын сорьц, дээж авахуулах, шинжилгээ хийлгэх, зөвлөгөө авах гэсэн шаардлагыг биелүүлсэн.

5) Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр:

2024 оны төсөвтөө байгаль хамгаалах зардал төлөвлөж зарцуулсан.

2.3. Хөрсний бохирдол, эвдрэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1) Нөлөөлөл үүсэх шалтгаан:

Үйлдвэрийн байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, газрын хэвлий эвдрэх, ухагдана. Мөн түүний эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох, талхлагдах, ургамлан нөмрөг устгах, бүрхэц нь багасахын зэрэгцээ тоос, үйлдвэрийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох нөлөөллүүд үүснэ.

2) Нөлөөлөлд өртөх объект:

Үйлдвэрийн орчны хөрс, газрын гадарга, түүгээр дамжин ойр орчмын хүн, амьтан, ургамал




Зураг-6. Хөрсний мониторингийн цэгүүд

3) Холбогдох стандарт, норм:

- MNS3297:1991. Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
- MNS5850:2008. Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Хүснэгт-4. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Үйлдвэрийн объектууд хооронд явган хүний замыг сэргээн засварласан	2024	Дотоод зардал	Үйлдвэр
2	Автомашинны нэгдсэн зогсоолын хатуу хучилтыг сэргээн засварласан	2024	Дотоод зардал	Үйлдвэр
3	Автомашинны чиглэл маршрутын дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зорчих замыг тодорхой болгон хатуу хучилтыг сэргээн засварлаж, зөвхөн тогтоосон маршрутаар явж хэвшсэн	2024	Дотоод зардал	Үйлдвэр
4	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон элэгдсэн хөрсийг нөхөн сэргээх зорилгоор 200 ш мод бут тарьж, орчныг ургамалжуулсан. Байнгын арчилгаа, тордлого хийж байсан.	2024	1,500,0	Үйлдвэр
5	Үйлдвэрийн хаягдал усыг вакуум насос ашиглан, гүний ус руу хийж, 100% хаягдалгүй болгох системээ сайжруулсан. Зөвхөн ууршилтын ус зарцуулагдана. Цементийн тээрмийн усыг төмөр силос суурилуулан буцаан ашигладаг болсоныг сайжруулалт хийсэн.	2024	5,000	Үйлдвэр
6	Үйлдвэрийн яндан болон автомашинны ашиглалтаас хөрсний бохирдол үүсч буй эсэхийг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлж, дүн шинжилгээ хийсэн	2024	200,0	Мэргэжлийн байгууллага
Дүн			6,700,0	



Зураг-7. Автомашинны зам, зогсоол болон шинээр тарьсан моднууд

4) Хяналт шинжилгээ явуулсан байдал:

Хөрсний бохирдлын түвшинг гадаад, дотоодын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, үйлдвэрийн хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэн, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулан ажиллав.

5) Хөрөнгийн эх үүсвэр

2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд байгаль хамгаалах зардал төлөвлөж хэрэгжүүлсэн.

2.4. Усан орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1) Нөлөөллийн үүсэх шалтгаан:

Газрын доорхи усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө. Мөн хүн, ургамал, мал амьтан, газрын доорхи усны хэрэглээг хэт нэмэгдүүлснээс газрын доорхи усны нөөц хомсдох, химийн бодис, урвалж агуулах боломжтой бохир ус хөрсөнд алдаж асгаснаас усан орчин бохирдох

2) Нөлөөлөлд өртөх объект

Үйлдвэрийн орчны хөрсны ус, газрын гадарга, түүгээр дамжин ойр орчмын амьтан, ургамал

3) Холбогдох стандарт, норм:

- Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол)
- MNS 4047:1988. Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам
- MNS 0899:1992. Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага
- MNS 4288:1995. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил цэвэрлэгээний технологийн түвшинд тавих үндсэн шаардлага
- Усны бохирдлоос хамгаалах журам (БО,ЭМ-ийн сайдын 1997 оны хамиарсан 143/352 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт)
- MNS 4586:1998. Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
- MNS 4943:2000. Усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 0900:2005. ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
- MNS 0900:2005. Ундны усны чанарын стандарт
- Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол)
- MNS 6148:2010. Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Хүснэгт-5. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Үйлдвэрийн болон ахуйн бохир ус дамжуулах шугам сүлжээний ашиглалтанд байнга хяналт тавьж, гэмтэж, эвдрэх, элэгдэх цоорохоос урьдчилан сэргийлж ажиллав.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
2	Усан хангамжийн худаг болон хаягдал усанд усны чанарын шинжилгээ хийлгэсэн.	2024	200,0	Мэргэжлийн байгууллага
3	Хур бороо, үерийн уснаас хамгаалах суваг, далан байгуулах замаар үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй бохирдуулах нөлөөллийг бууруулах арга хэмжээг авсан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
4	Түр ашиглах шингэн хаягдлын цооног дотор хучилтыг сайжруулах, хаягдлыг анхан шатны ариутгал хийн, графикийн дагуу орон нутгаас зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулсан	2024	700,0	Үйлдвэр
5	Усны хэрэглээг тоолууржуулж, жилийн нийт хэрэглэсэн усны хэмжээгээр төлбөрийг төлсөн.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
6	Үйлдвэрийн хөргөлтөөс гарч буй усыг үйлдвэрийн технологийн процесст 100% эргүүлэн ашиглахын зэрэгцээ жил бүрийн физик, хими, бактериологийн шинжилгээний дүнд тулгуурлан ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд усалгааны зориулалтаар ашиглаж, үйлдвэрийн төв цэгт усан оргилуур байгуулж, тоос бууруулагч автомат систем суурилуулав.	2024	Дотоод зардал	Мэргэжлийн байгууллага
Дүн			900.0	

2.5. Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1) Нөлөөллийн үүсэх шалтгаан:

Үйлдвэрийн талбайн ажиглалтаас харахад тухайн байгалийн унаган ургамал тодорхой хэмжээгээр алдарсан, дунд зэргийн доройтолд орсон байсан. Иймд үйлдвэрийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага юм. Үйлдвэрийн үйл ажиллагаагаар 1.02 талбайг нэмж, 1.31 га болгон хүрээлсэн ногоон байгууламж барисан бөгөөд бөгөөд энэ нь тухайн орчны хөрс, ургамал, амьтны аймагт эерэгээр нөлөөлсөн. Авто тээврийн хэрэгсэл замгүй газраар зорчих, хүн амын хэт бөөгнөрөл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас ургамлан бүрхэвч нөлөөлөлд өртөж болзошгүй нөлөөллийг арилгасан. Бохирдол, эвдрэлийн эх үүсвэр нь:

- Авто хөсгийн зам, зогсоолын талбай, түүний орчин
- Явган хүн ихээр холхидог сууц, үйлчилгээний барилга байгууламж орчны талбай
- Барилга байгууламжийн талбай
- Тоосжилт

2) Нөлөөлөлд өртөх объект

Үйлдвэрийн орчны ургамал, хөрс

3) Холбогдох стандарт, норм:

- MNS 5914-2008 - Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Тодорхойлолт

- MNS 5918-2008 - Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага

Хүснэгт-6. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглосон газрыг байнгийн хяналтанд авч ажилласан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
2	Талбайн хил хязгаарыг тойруулан үйлдвэрийн талбайд мал амьтан орохоос сэргийлэн бетон хийц бүхий хашлагыг сайжруулсан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
3	Үйлдвэрийн нутаг дэвсгэр дэх нөлөөллийн талбайг нэмэгдүүлэхгүй байх, бусад нутаг дэвсгэрийг хамгаалах зорилгоор үйлдвэрийн барилга байгууламжуудын ойролцоо боломжтой газруудад ногоон байгууламж байгуулж, байнга арчилж тордож байсан.	2024	Дотоод зардал	Мэргэжлийн байгууллага
4	Ногоон байгууламжийн барьж байгуулах зөвлөгөө, зөвлөмжийг мэргэжлийн байгууллагаас авч, ногоон байгууламж хийж, түүнийг тойруулан хашилт хаалт хийсэн	2024	1500,0	Мэргэжлийн байгууллага
Дүн			1,500,0	

4) Хяналт шинжилгээ явуулсан байдал:

Нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг үйлдвэрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэсэн.

5) Хөрөнгийн эх үүсвэр

Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд байгаль хамгаалах зардал төлөвлөж хэрэгжүүлсэн.

2.6. Оршин суугчид, ажиллагсадын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалын чиглэлээр сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1) Нөлөөлөл үүсэх шалтгаан:

Үйлдвэрийн бутлалт, тээрэмдэлт, шатаах системийн хэсэгт ажиллах ажилчид тоосжилт, дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчин болон үйлдвэрийн техник технологийн үйл ажиллагаанаас үүсэх физик бохирдолттой хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллах тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөж болзошгүй. Иймд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын хувийн хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаж, аюулгүй ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм, норм стандартыг хатуу мөрдөх шаардлагатай.

2) Нөлөөлөлд өртөх объект:

Үйлдвэрийн ажилчид, орон нутгийн иргэд

3) Холбогдох стандарт, норм:

- MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага
- MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
- MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”

- MNS5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
- MNS5105:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, тавигдах шаардлага
- MNS ILO OSH1:2003. ХААЭА-н удирдлын тогтолцооны талаарх удирдамж
- MNS ILO OSH0:2003. ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
- MNS5002:2000. ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS5390:2004. ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
- MNS ISO13688:2000. ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага

Хүснэгт-7. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
<i>Орон нутгийн иргэдийн нийгэм-эдийн засгийн нөлөөллийг бууруулах</i>				
1	Орон нутгийн иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг орон нутгаас худалдан авсан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
2	Ажиллах хүчийг орон нутгаас бүрдүүлэх, сургах зорилгыг жил бүр тогмол тавьж ажилладаг. Сургалт зохион байгуулж мэргэжилтэй ажилтан болгож бэлтгэв.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
3	Нийгмийн хариуцлагын хүрээнд Налайх дүүргийн 4-р хорооны хүүхдийн баярт.	2024	2,000,0	Үйлдвэр
<i>Ажиллагсдын нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал</i>				
3	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангав.	2024	ХАБЭА-н зардал	Үйлдвэр
4	Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж, ажиллагсдад сургалт явуулж байх арга хэмжээ авав.	2024	900,0	Үйлдвэр
5	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын иж бүрэн багаж шинэчилсэн.	2024	500,0	Үйлдвэр
6	Анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан байршуулсан.	2024	Дотоод зардал	Үйлдвэр
Дүн			3,400,0	

4) Хяналт шинжилгээ явуулсан байдал:

Дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн.

5) Хөрөнгийн эх үүсвэр:

2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд байгаль хамгаалах зардал төлөвлөж хэрэгжүүлсэн.



Зураг-8. Эвдэрсэн хөрс нөхөн сэргээгдсэн байдал.



Зураг-9. Нөхөн сэргээгдсэн талбайд ажилчидын наадам хийсэн байдал

2.7. Удирдлага, зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах зохион байгуулалт, төлөвлөлт болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг “Налгартүшиг” ХХК бүрэн хариусан ажилласан. БОМТ, ОХШХ-ийг 2024 оны биелэлтийн тайлан, 2024 оны төлөвлөгөө, хөтөлбөрийг 11-р сарын 01-нээс өмнө Байгаль орчин уур амьсгалын ямаар баталгаажуулахаар хүргүүлсэн болно. БОМТ-ын хүрээнд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөг дотоод хяналт, шалгалтын жилийн төлөвлөгөөнд тусган ажиллахын зэрэгцээ төлөвлөгөөний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Үйлдвэрийн удирдлага дараах асуудлыг хариуцан ажиллав.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг жил бүрийн төсөвт тусган саадгүй төлж хэрэгжүүлсэн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулж тухайн засаг захиргааны гаргасан шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.
- Хяналт шинжилгээний үр дүнг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн гаргасан.

1) Нөлөөллийн үүсэх шалтгаан:

Төслийг хэрэгжүүлэх явцад хэрэгжүүлэгчийн зүгээс байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, буруу хэрэгжүүлсэн тохиолдолд үйлдвэрийн талбай болон түүний нөлөөллийн хүрээнд байгаль орчны доройтол бий болно.

2) Нөлөөлөлд өртөх объект:

Байгаль орчны бүх орчин, үйлдвэрийн ажилчид, орон нутгийн иргэд

Хүснэгт-8. Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Байгаль орчныг хамгаалах, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг Налайх дүүргийн ОБЕГ-тай хамтран хийж гүйцэтгэсэн.	2024	1,700,0	Мэргэжлийн байгууллага
2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг Нийслэлийн БОГазар болон Налайх дүүргийн тамгийн газарт 2024.11.01-ны өдөр хүргүүлэв.	2024	Дотоод төлөвлөлт	Үйлдвэр
3	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөлгөөн зохион байгуулалж, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгасан.	2024	1,000,0	Үйлдвэр
4	Үйлдвэрийн хүрээнд байгаль орчны мэргэжилтэнүүд, компаниудтай нягт хамтран ажиллаж, тэдний заавар зөвлөгөөг тогтмол хэрэгжүүлэн ажилласан.	2024	500,0	Мэргэжлийн байгууллага
Дүн			3,200,0	

3) Хөрөнгийн эх үүсвэр

Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд байгаль хамгаалах зардал төлөвлөж хэрэгжүүлсэн.



Зураг-10. Үйлдвэрийн ажилчидад болон НД-ын 4-р хорооны иргэдэд компанийн байгаль, орчны бодлого, хэрэгжилтийн талаарх тайлан сургалт




Зураг-11. Гамшигаас хамгаалах, галын аюулгүй байдал, гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлдвэр дээрх сургалт зохион байгуулагдаж буй байдал

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нөхөн сэргээлтийн гол зорилго нь үйлдвэрийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын сөрөг нөлөөллөөс үүссэн хөрсний элэгдэл, доройтлыг байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор ногоон байгууламжийг барьж байгуулах явдал юм. Энэ төслийг бодитойгоор хэрэгжих үндэс болсон цаг агаарын нөхцөл, хөрсний хэв шинжид зохицсон мод, сөөг, олон наст ургамал сонгосон ба эдгээр нь дасан зохицол сайтай, үр жимсээ амархан өгдөг, манай орны хээр, ойт хээр, хангайн бүс бүслүүрт ургах чадвартай. Түүнчлэн нөхөн сэргээлтэд сонгосон ургамлын зүйлүүд нь нийслэл хотын ногоон байгууламжид өргөнөөр ашиглагддаг бөгөөд үр дүн сайтай болох нь та бидэнд харагдаж байдаг.

Тус ногоон байгууламжыг амжилттай тариалснаар байгаль орчинд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ үйлдвэрлэлийн талбайн тодорхой хэмжээний хөрсийг хамгаалж элэгдэл эвдрэлд өртүүлэхгүй байх, хамгийн чухал нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс бууруулах, цаашилбал байгаль орчны талаас компанид ирээдүйд учирч болох эдийн засгийн алдагдлаас сэргийлж, тухайн байгууллагын “**ногоон бодлогыг**” илтгэх ач холбогдолтой. Мөн уг ногоон байгууламжийг барьж байгуулсанаар үйлдвэрийн ажилчид амралтын хугацаагаа өнгөрүүлэх цэцэрлэгт талбай болж байгаа юм..

Үйлдвэрийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь төлөвлөгөөт он бүрт хаврын улиралаас хэрэгжиж эхэлсэн. Уг нөхөн сэргээлтийн төсөлд тусгагдсанаар үйлдвэрийн хашаан дотор нөхөн сэргээлт хийж болох 1,02 га талбайд нөхөн сэргээлт хийж мод, ургамал тарьж, бусад газруудад байнгын арчилгаа хийж байв.



Зураг-12. Үйлдвэрийн ногоон байгууламж байгуулсан талбай



Зураг-13. Үйлдвэрийн ногоон байгууламжийн байдал

Уг төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт онд нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг сайжруулж, усалгаа, арчилгааг сайн хийж шаардлагатай хөрөнгийг компанийн дотоод зардлаар шийдвэрлэн гүйцэтгэсэн.

ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус “Горхи-Тэрэлжийн үндэсний цогцолборт газар”-нь Налайх дүүргийн нутагт хамаарагдана. Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Туркийн Таньюкухийн хөшөө, мөн Зуун модны тулалдааны талбай зэрэг түүхийн дурсгалт газрууд бий. Цементийн үйлдвэрийн байршил, үйл ажиллагаа нь эдгээр түүх соёлын дурсгалт газруудад нөлөөлөхгүй юм. Гэвч үйлдвэрийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олоход аваас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны анхдагч нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, үйлдвэрийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шаардлагатай.

ТАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019 онд “Нью ларус” ХХК-аар тус цементийн үйлдвэрийн шинжилгээний лабораторидоо химийн бодисын нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж БОНХАЖЯ-аар батлуулсан байна. 2024 онд нэмэлт тодотголын “Флуорексон” ХХК-аар хийлгүүлж байгаа ба одоогоор Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарч, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд шүүмжинд өгөх шатанд явж байна.

ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хатуу хог хаягдал:

Цементийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагааны явцад эргэх зуухны наалдац жилд 20-30 тн гарахаар тооцсон боловч судалгаа шинжилгээний үндсэн дээрхи хаягдлыг 008 номерийн шигшүүр дээрхи үлдэгдэл 1% хүртэл нунтаглан цементийн нэмэлтээр 0.2% хүртэлхи нэмэхэд цементийн чанарт өөрчлөлт гарахгүй болохыг тогтоосон. Зуухны доторлогоог жилд 1 удаа солих бөгөөд 4-5 тн хаягдал гарна. Доторлогооны тоосгыг ногоон байгууламж хүрээлсэн хашилт хэлбэрээр ашиглах, орон нутгийн иргэд болон ажилчидад гэрийн зуухны доторлогоонд өгөх зэргээр ашиглаж байна. Цементийн үйлдвэрээс жилд дунджаар 25.0-35.0 тн хатуу хог хаягдал гарах бөгөөд хог хаягдлыг үйлдвэрээс 10 км зайд орших Налайх дүүргийн хогийн цэгт хаядаг.

Үйлдвэрийн түүхий эд шатаахад ашигласан нүүрсний үнс нь клинкертэй холилдон цементийн түүхий эд болох тул хаягдал болохгүй юм.

Цементийн үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд их хор нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь агаарт хаягддаг тоосонцор хаягдал юм. Мөн тоосонцор нь хүний эрүүл мэндэд маш муугаар нөлөөлнө. Тоосонцор хаягдлын ихэнхи хэсэг нь 10 микроноос бага хэмжээтэй байдаг. Зуухнаас гарч буй хий нь тоосонцорын гол эх үүсвэр болно. Гэхдээ тоосонцорыг шүүж, эргэх зууханд эргүүлэн хийх бололцоотой. Иймд тоос тоосонцорыг шүүх системийн найдвартай ажиллагааг хангаж тоосонцорын эх үүсвэрүүдэд үүсэх тоосны хэмжээг бууруулахад гол анхаарлаа тавьж ажиллах шаардлагатай.

Хатуу хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зэрэг арга хэмжээнд тулгуурлана. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд их хөнөөлтэй. Жишээлбэл, модон хаягдал 15 жилийн дараа бүрэн задарч дуусдаг бөгөөд будагтай бол задралд орох хугацаа нь бүр ч удааширдаг. Шил болон түүний хэмхдэс нь 400 гаруй жилийн хугацаанд

байгальд тогтвортой оршин, орчныг бохирдуулсаар байдаг. Хөнгөнцагаан сав болон металл лааз нь устаж үгүй болтлоо 10-100 жил зарцуулдаг бол ердийн цаас доод тал нь 3 сарын турш нар, усанд автаж байж задарч устдаг байна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах хатуу хог хаягдал:

Тус үйлдвэрт 110 хүн ажилладаг тул хоногт $110 * 0,3 \text{ кг} = 33 \text{ кг}$, сард 990 кг, жилд 9900 кг хатуу хог хаягдал гарах тооцоо гарна. Хатуу хог хаягдлын ихэнх нь цаас, хүнсний хог хаягдал, сав баглаа боодол эзлэнэ. Дээрхи тооцоо нь тухайн жилийн ажиллах хүчнээс хамаарч 1-5 тооны ажилчдын зөрүүнээс хамаарч бага зэрэг хэлбэлзэж болно.

Хүснэгт-9. Хатуу хог хаягдлын жилийн нэгдсэн тооцоо

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн хатуу хог хаягдлын хэмжээ					
Хоногт, кг	Сард, кг	Жилд, кг	Сард тээвэрлэх хуваарь	Жилд тээвэрлэх хуваарь	Тээвэрлэлтийн нийт зардал, мян. төг
33	990	9900	1,5 удаа	10 удаа	1020,0
Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах үйлдвэрийн хатуу хог хаягдлын хэмжээ					
Хоногт, кг	Сард, кг	Жилд, кг	Сард тээвэрлэх хуваарь	Жилд тээвэрлэх хуваарь	Тээвэрлэлтийн нийт зардал, мян. төг
-	3,75	30	1 удаа	8 удаа	680,0
Нийт			2,5 удаа	18 удаа	1700,0

Хог хаягдлыг зайлуулахдаа “Хог хаягдлын тухай ” Монгол улсын хуульд заасны дагуу Налайх дүүргийн ТҮК-тай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэсэн.

Шингэн хог хаягдал:

Үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарахгүй. Дээрх хэрэглэсэн усны 70% нь ахуйн бохир ус байдлаар шингэн хаягдал болно. Бохир усаа үйлдвэрийн хашаанд байрласан бетонон доторлогоотой бохирын хоолойд хаяна. Бохир усны хэмжээ нь унд ахуйн ус хэрэглээнээс хамаарна. Бохир ус хальж орчныг бохирдуулахаас сэргийлэх, бохирын сангийн усны түвшинд хяналт тавьж ажилладаг.

Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын эх үүсвэр нь:

- ✓ Хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус
- ✓ Цэвэрлэгэнд хэрэглэсэн бохир ус
- ✓ Ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус зэрэг болно.

Хүснэгт-10. Шингэн хог хаягдлын жилийн нэгдсэн тооцоо

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах шингэн хог хаягдлын хэмжээ					
Хоногт, тн	Сард, м³	Жилд, м³	Сард тээвэрлэх хуваарь	Жилд тээвэрлэх хуваарь	Тээвэрлэлтийн нийт зардал мян. төг
1,31	39,3	314,4	4	32	1440,0

Жич: Тусгайлан гаргасан графикийн дагуу тухайн бүр нь тээвэрлэн хог хаягдлыг зайлуулдаг болно. Хог хаягдлыг зайлуулахдаа “Хог хаягдлын тухай ” Монгол улсын хуульд заасны дагуу Налайх дүүргийн ТҮК-тай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэдэг.

Бохир усыг зайлуулах нөхцөл:

Үйлдвэрийн ахуйн хэрэглээнээс гарах ахуйн бохир усыг газрын хөрсний доор, зохих түвшинд байрлалтай бохир ус түр агуулах санд хуримтлуулж, тусгай зөвшөөрөлтэй газарт Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай хийсэн гэрээний дагуу ТҮК-ийн машин, тоног төхөөрөмжөөр зайлуулна. Бохир ус түр агуулах сан нь дараах шаардлагыг хангасан байна.

- Ариун цэврийн өрөө болон ахуйн хэрэглээнээс гарч байгаа бохир шингэнийг хуримтлуулах 10-15 метрийн багтаамжтай бетонон доторлогоотой бохирын цооног байх
- Ахуйн бохир ус хуримтлуулах цооногийг барьж байгуулахдаа БО-ны Сайд, ЭМ-ийн Сайдын 1995 оны 169/171 тоот тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах ба цооногийг барьж дууссаны дараа Налайх дүүргийн байгаль орчны байцаагчид үзүүлэн шалгуулж, бохирын цооног ашиглах зөвшөөрөл авах
- Бохирын цооногт хуримтлагдсан бохирыг цооногийн ээлэхүүний 70-80%-иас хэтрүүлэхгүйгээр буюу дээр тооцоолсон хуваарийн дагуу зориулалтын бохирын машинаар соруулан зөвшөөрөгдсөн цэгт БО-ны байцаагчийн хяналтан дор хаяж зайлуулж байх
- Цооногийн амсарыг таг, сараалжтай болгохын зэрэгцээ хяналтын цонх (труба) суурилуулах
- Цооногт борооны ус шүүрч, нэвтрэхээс сэргийлэх зорилгоор тодорхой хэмжээний налуутайгаар тэгшлэн бохирын машины зогсоолын хамт хатуу хучилт хийх
- Бохирын цооногт хатуу хог хаягдал хаяхыг хориглохын зэрэгцээ жил бүр тогтоосон хугацаанд хортон, шавьжны устгалыг орчных нь хамт хийлгэж байх.
- Хаягдал бохир ус цэвэршүүлэх төхөөрөмжийг ашиглах

Хийн хог хаягдал:

Цементийн үйлдвэрийн эргэдэг зууханд чулуунцар хатаах ба шатаахад түлшний шаталтаас үүсэх утаа, хорт хий (SO_2 , NO_2) нь агаарт хаягдана. Энэ нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно. Үйлдвэрлэлийн явцад нүүрс шатаалтаас үүсэх химийн олон нэгдлүүд агаарт орчинд цацагдаж орчныг бохирдуулах бөгөөд эдгээрийн тархалтын орон зайг математик загварчлалаар гаргаж тооцсон үр дүнгээс үзэхэд яндангийн өндөр 30 м, амсарын диаметр 1 м байхад салхигүй тогтуун үед агаарт дахь бодисын хүлцэх агууламжтай харьцуулахад тархалтын радиус 5 км, 5 м/с салхитай үед 4 км байхаар тооцоо гарсан. Үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх хамгийн гол сөрөг нөлөө нь агаар орчны бохирдол байна.

Химийн болон цацрагт идэвхит бодисын хаягдал:

Цементийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанаас цацраг идэвхит бодисын хаягдал гарахгүй бөгөөд химийн хорт бодис болох полихлорт дибензо-п-диоксинууд (ПХДД), полихлорт дибензофуранууд (ПХДФ), полихлорт бифенилүүд (ПХБ), гексахлорбензол (ГХБ) зэрэг нь ялгарна. Эдгээр хоруу чанар өндөртэй химийн бодисын асуудлыг манай улс нэгдэн орсон Стокгольмийн конвенциор зохицуулдаг.

Цементийн зуух нь клинкер үйлдвэрлэх үндсэн зориулалттай юм. Энэ зууханд ашигт малтмалын төрлийн түлш буюу минералыг орлуулан эрчим хүч гаргаж авах зорилгоор хаягдал шатааж болдог. Цемент үйлдвэрлэх процесст: кальцийн карбонатыг (CaCO_3) 900°C -д задлан кальцийн исэл гаргаж, дараа нь 1450°C -т эргэх зууханд түлшээр шатаан боловсруулалт хийж клинкер гарган авдаг. Цемент гаргаж авахын тулд үүссэн клинкерийг гөлтгөнө болон бусад нэмэлтүүдтэй хамт тээрэмдэн нунтагладаг.

Цементийн зуухыг аюултай хог хаягдал шатаах зорилгоор ашиглахад, зөв төлөвлөгдсөн үйлдвэрийн процесс, зохих ёсны үндсэн арга хэмжээ зэрэг нь цэвэр түлш хэрэглэх, зууханд хийх хаягдлын хэмжээг тохируулах, температурын горимыг сахих, тоос

зайлуулах зэргээс шалтгаалан, химийн бодис үүсэх, хаягдахыг хамгийн доод түвшинд хүргэж чадна. Энэ түвшин нь гарч байгаа хийнд ПХДД/ПХДФ-ны концентрац (хүчилтөрөгчийн агуулга 10% байхад) 0.1 нг I-TEQ/нм³ байх хэмжээ юм. ПХДД/ПХДФ цементийн зуухны тоостой, магадгүй, клинкертэй хамт хаягдаж байдаг.


Шинж чанар

Эдгээр химийн бодисуудын хоруу чанар нь олон улсын хэмжээнд нотлогдож, баталгаажсан бөгөөд эдгээр бодис нь удаан задардаг, гадны нөлөөнд тэсвэртэй, биохуримтлал үүсгэдэг, хол зайд тархах чадвартай. Гадны нөлөөнд тэсвэртэй химийн бодисууд нь хүрээлэн байгаа орчинд хурдан задардаггүй. Биохуримтлалд ордог химийн бодисууд нь гол төлөв тосонд уусамтгай бодисууд байдаг бөгөөд хүн мэтийн дээд түвшингийн организмд хуримтлагддаг. Эдгээр бодисууд нь хагас дэгдэмтгий учраас хүрээлэн байгаа орчинд уурших, конденсацлагдах зэргээр тархах чадвартай.

Хүлцэх хэмжээ

Хоногийн хүлцэх тун (TDI) нь амьдралын туршид өдөр бүр авахад эрүүл мэндэд онцын хор нөлөө үзүүлэхгүй байх биеийн жингийн кг тутамд ноогдох тухайн бодисын тун хэмжээг хэлнэ. 1998 онд ДЭМБ-аас TEQ нь (хоруу чанарын эквивалент) тодорхойлсон химийн бодисын хувьд хортой нөлөө үзүүлэхгүй тунг TDI-г (хортой нөлөө үзүүлэхгүй хамгийн их тун, хэмжээ) өдөрт 1-4 пг/кг биеийн жинд байхаар тогтоосон. 2001 онд ДЭМБ, ХХААБ (Хүнс,хөдөө аж ахуйн байгууллага)-ын хүнсний нэмэлт бүтээгдэхүүний шинжээчдийн хамтарсан комиссоос хортой нөлөө үзүүлэхгүй сарын тун, хэмжээг 70 пг/кг-биеийн жинд гэж тогтоосон байгаа нь, өдөрт ойролцоогоор 2,3 пг/кг-биеийн жинд оногдож байгаа юм.

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР



Зураг-14. Үйлдвэрийн ОХШХ-н хяналтын цэгүүд

7.1. Агаар орчны бохирдол:

Орчны агаарын чанарын үзүүлэлтийг дараах стандартын дагуу хэмжин, шинжилгээ хийсэн:

- MNS 4048:1988, Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга;
- MNS 5365:2004 Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга;
- Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 зэрэг стандарт түүнд заагдсан аргуудыг үндэслэн тооцоолсон.

Агаарын чанарын судалгаа:

Үйлдвэрийн талбайд өнөөгийн байдлаар цемент үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явагдаж байна. Тус үйлдвэрийн бүсэд үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор тоосжилт, дуу чимээ ихээхэн хэмжээтэй үүсэж, агаарын чанарт нөлөөлж байна. Иймд тус үйлдвэрийн үйл ажиллагаанаас гадаад болон дотоод агаарын чанарт нөлөөллийн хэмжээг үйлдвэрийн бүсийн хашааны дотор болон гадна зонхилох салхины чигийн дагуу 8 цэгт тодорхойлж, Монгол Улсын агаарын чанарын MNS 4585:2007 стандартын үзүүлэлтүүдтэй харьцуулж, агаарын чанарын индексээр илэрхийлэхийг зорьсон.

Агаарын чанарыг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор хэмжилт, судалгааг хийлгэсэн. Үйлдвэрийн талбайн хими, физик нөлөөллийг хэмжиж, агаарын чанарын индексээр тооцож дараах хүснэгтээр илэрхийлэв



Зураг-15. Тоосны хэмжилт хийсэн цэгүүдийн байршил

